



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/19

Улаанбаатар хот


「Баянгол дүүргийн 133 дугаар цэцэрлэгийн
барилгын бүртгэлийн үнийг нэмэгдүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 594,570,878 (таван зуун ерэн дөрвөн сая таван зуун далан мянга найман зуун далан найм) төгрөгөөр цэцэрлэгийн барилгын бүртгэлийн үнийг нэмэгдүүлэн бүртгэж авахыг Баянгол дүүргийн 133 дугаар цэцэрлэг (Т.Нарантуяа)-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянгол дүүргийн 133 дугаар цэцэрлэг (Т.Нарантуяа)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.



ДАРГА ~~М.БАЯРАА~~ М.БАЯРАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
2022 оны 02 дүгээр сарын 01-ны өдрийн
4/19 дугаар тушаалын хавсралт

Бүртгэлд авах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн 133 дугаар цэцэрлэг

/төгрөгөөр/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Чанар байдал	Гүйцэтгэлийн дүн	Хандивлагч байгууллага	
						Нэр	Эх үүсвэр
1	133 дугаар цэцэрлэгийн барилгын дулаан хамгаалалтын ажил /БГД, 9 дүгээр хороо/	Их засвар	2021	сайн	594,570,878	Дэлхийн банкны санхүүжилттэй "Улаанбаатар хотын цэвэр агаар нэмэлт санхүүжилтийн төсөл"	Төсөл, хөтөлбөр
Барилгын бүртгэлийн үнийг нэмэгдүүлэх дүн					594,570,878		